



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Аудитын тайлан

ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ БҮРЭН ХАНГАЖ АЖИЛЛААГУЙГЭЭС ГАЗРЫН ТОСНЫ ЗАВСРЫН НЭМЭЛТ БҮТЭЭГДЭХҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ ЭЗЭНГҮЙДЭЖ БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ГАЗРЫН ТОС, НЕФТИЙН ЗАВСРЫН НЭМЭЛТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АДГ-2022/19-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням

Утас: 260949, цахим хаяг: Sambuunyamya@audit.gov.mn

Аудитын менежер Х.Болдбаатар

Утас: 261729, цахим хаяг: Boldbaatarakh@audit.gov.mn

Ахлах аудитор И.Эрдэнэцэцэг

Утас: 261729, цахим хаяг: Erdenetsetsegi@audit.gov.mn

Аудитор Ж.Дэмчигсүрэн

Утас: 261729, цахим хаяг: Demchigsurenja@audit.gov.mn

Аудитор Д.Батчимэг

Утас: 261729, цахим хаяг: Batchimegd@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын тайланг хавсралт ёсоор баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газарт тус тус хүргүүлэхийг Аудитын дөрөвдүгээр газар (Я.Самбууням)-т даалгасугай.

3.Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (Г.Ёндон), Ашигт малтмал газрын тосны газар (Л.Баярмандал), Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Б.Баасандорж), Гаалийн ерөнхий газар (Б.Асралт)-т тус тус зөвлөсүгэй.

4.Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, аудитын тайлан, ажлын баримтыг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын архивд шилжүүлэн ажиллахыг Аудитын дөрөвдүгээр газар (Я.Самбууням)-т үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч (Я.Сарансүх)-д даалгасугай.

Д.ЗАНДАНБАТ

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРАГ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	5
БҮЛЭГ 1. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГЫН ЗОРИЛТ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ, ХУУЛИАР ТОГТООСОН ЭРХ ЗҮЙН АКТУУДЫГ БҮРЭН БОЛОВСРУУЛЖ БАТЛААГҮЙ, ЗАСГИЙН ГАЗАР, ЯАМ, АГЕНТЛАГ ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.....	8
<i>Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод тусгасан арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.</i>	<i>8</i>
<i>Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Евро-5 стандартын шатахууныг импортлох нийт шатахууны 50 хувьд хүргэх зорилт хэрэгжээгүй байна.</i>	<i>9</i>
<i>Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнд хяналт тавих төрийн байгууллагуудын эрх зүйн орчин, зарим чиг үүрэг тодорхойгүй, ажлын уялдаа хангалтгүй байна.....</i>	<i>12</i>
БҮЛЭГ 2. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНГҮЙ БАЙНА.	15
<i>Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөлд үндэслэн аж ахуйн нэгжүүдэд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.</i>	<i>15</i>
<i>Монгол Улсын хилээр импортлох газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг ОАТ-т бүрэн хамруулж, хуулийн дагуу татвар суутгаж төсөвт төвлөрүүлсэн байна.</i>	<i>18</i>
ДҮГНЭЛТ	19
ЗӨВЛӨМЖ.....	20
ХАВСРАЛТУУД:.....	22
<i>Хавсралт 1</i>	<i>22</i>
<i>Хавсралт 2</i>	<i>23</i>
<i>Хавсралт 3</i>	<i>25</i>
<i>Хавсралт 4</i>	<i>26</i>
<i>Хавсралт 5</i>	<i>28</i>
<i>Хавсралт 6</i>	<i>29</i>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АХЦС	Автомашинг хийгээр цэнэглэх станц
БТКУС	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ГТЗБНБ	Газрын тосны завсрын болон нэмэлт бүтээгдэхүүн
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ОАТ	Онцгой албан татвар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль

ЗУРАГ, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Дүрслэл-1	2017-2021 онуудад импортолсон газрын тосны нийт бүтээгдэхүүн
Дүрслэл-2	Газрын тосны бүтээгдэхүүний импорт
Дүрслэл-3	Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний импорт
Дүрслэл-4	Евро-5 стандартын шатахууны импорт
Дүрслэл-5	Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт хийх үе шат
Дүрслэл-6	Аж ахуйн нэгжийн импортын мэдээ
Дүрслэл-7	Бүх төрлийн шатахууны 2017-2021 оны импорт болон борлуулалтын

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Хүснэгт-1	Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний импорт тонн /2017-2021/
Хүснэгт-2	Төрөөс газрын тосны талаар баримтлах бодлогын хүрэх түвшний үнэлгээ
Хүснэгт-3	Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд тусгасан хүрэх түвшин
Хүснэгт-4	Хөтөлбөрийн хэрэгжилт
Хүснэгт-5	2021 оны байдлаар үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчинтэй байгаа 7 аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрийн судалгаа
Хүснэгт-6	Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний импорт төрлөөр
Хүснэгт-7	Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний 2021 оны импорт аж ахуйн нэгжээр
Хүснэгт-8	Аж ахуйн нэгжийн импортын бүтээгдэхүүний мэдээ
Хүснэгт-9	Онцгой албан татварын тооцоолол

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, үр дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилгыг чиглүүлж, дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого үр нөлөөтэй эсэх;
- Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлэх бодлого боловсруулах, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар зэрэг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудын 2017-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос гаргасан АДБОУС 100, 300, 3000 стандартад нийцүүлэн баталсан дараах стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав. Үүнд:

- *Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”;*
- *MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”;*
- *MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”;*
- *MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”.*
- *MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”.*

Салбарын бодлого, хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт, уялдаа холбоо болон мөрдөж буй хууль, эрх зүйн актын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулан аудитад хөндлөнгийн мэргэжлийн шинжээч авч ажиллав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Хууль:

- Газрын тосны тухай хууль;
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль;
- Гаалийн тухай хууль;
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Онцгой албан татварын тухай;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Холбогдох бусад хууль.

Улсын Их Хурлын тогтоол:

- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр/,
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар/,
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин
- “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” /2016 оны 45 дугаар тогтоол/,
- “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” /2020 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 24 дүгээр/,

Засгийн газрын тогтоол:

- “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого” /2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 169 дүгээр/,
- “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” /2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 98 дугаар/,
- “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” /2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр/,
- “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” /2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан./

Сайдын тушаал:

- “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам” /УУХҮС-ын 2013 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 171 дүгээр, 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/08 дугаар тушаалаар баталсан/.

Стандартууд:


- MNS 0216:2017 дизелийн түлш Евро. Техникийн шаардлага;
- MNS 0217:2017 хөдөлгүүрийн түлш Этилжүүлээгүй бензин. Техникийн шаардлага;
- MNS 6854:2020 Алкилат. Техникийн шаардлага;
- MNS 6855:2020 Керосин. Техникийн шаардлага;
- MNS 6856:2020 Шууд нэрлэгийн бензин (Нафта). Техникийн шаардлага;
- MNS 6857:2020 Үнэрт нүүрс-устөрөгчид буюу риформат. Техникийн шаардлага;
- MNS 6859:2020 Хүнд фракцын дизелийн түлш. Техникийн шаардлага;
- MNS 6860:2020 Метил три-бутилийн эфир (МТБЭ). Техникийн шаардлага;
- MNS 6861:2020 Дизелийн түлш. Техникийн шаардлага.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хотын агаарын бохирдлын 80 орчим хувийг гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын халаалтын зуух, 10 орчим хувийг замын хөдөлгөөнд оролцож байгаа 660 мянга гаруй авто тээврийн хэрэгсэл, 5-6 хувийг дулааны цахилгаан станцууд, 4 орчим хувийг үнсэн сан, замын тоос шороо, ил задгай хаясан хог хаягдал болон бусад эх үүсвэр ялгаруулж байгаагийн улмаас хүрээлэн байгаа орчны бохирдол ихсэж, байгаль орчин төдийгүй хүний амьдрах нөхцөл, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.


Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ 2021 оны байдлаар 1.8 сая тонн байгаа бөгөөд 100 хувь импортлож, үүний 94 хувийг ОХУ-аас нийлүүлдэг байна.

Дүрслэл-1



Эх сурвалж: ГЕГ-аас ирүүлсэн тоо мэдээ

Дүрслэл-2



Агаар орчныг бохирдуулагч эх үүсвэрийн нэг болох шатахууны хэрэглээний сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэтэй уялдуулан 2015 оны 11 дүгээр сараас Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг боомтуудаар импортлож буй авто бензинд тонн тутамд 400,000 төгрөг, дизель түлшинд 520,000 төгрөг, Эрэнцав боомтоор импортлож буй авто бензинд 270,000 төгрөг, дизель түлшинд 290,000 төгрөгийн онцгой албан татвар тус тус ногдуулах болсон байна.

Ингэхдээ авто бензин, дизелийн түлшинд онцгой албан татвар тогтоож, газрын тосны завсрын болон нэмэлт бүтээгдэхүүнд татвар тогтоогоогүйгээс 2016 оноос газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний импорт эрс нэмэгдэж, 2015 оны импортын хэмжээг 2021 онтой харьцуулахад керосины импорт 10 дахин, газрын тосны хүнд фракцын нэгдлийн импорт 47 дахин өссөн байна.

Дүрслэл-3



/Эх сурвалж: АМГТГ-ын тоон мэдээнээс/

Харин 2021 оны 8 дугаар сараас газрын тосны зарим бүтээгдэхүүнд онцгой албан татвар тогтоосонтой холбоотой 2020 оны импортыг 2021 онтой харьцуулахад импортолсон газрын тосны хүнд фракцын нэгдэл 2 дахин, хөнгөн нэрлэгийн фракц нафта 3 дахин буурсан байна.

Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний импорт тонн /2017-2021/

Хүснэгт1

Нефтийн завсрын бүтээгдэхүүн	2015	2016	2017	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Алкилат зэрэг нефть, химийн бүтээгдэхүүн	6733	7836	9024	9156	4050	-	-	22229	3%
Керосин	4470	59422	49738	109325	52445	45115	44613	301236	37%
Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц, нафта	8786	20784	24120	18976	7112	5291	1891	57389	7%
Нефтийн нэрлэгийн хүнд фракц	1718	2569	24814	96794	87915	151827	80595	441944	54%
Нийт дүн	21707	90611	107695	234250	151522	202233	127098	822798	100%
ОАТ-ын алдагдсан боломж, тэрбум төг			30.69	66.76	43.18	57.64	-	198.27	

Монгол Улсын хилээр импортолж байгаа газрын тосны бүтээгдэхүүний нэр төрлийг хууль, эрх зүйн актууд болон гаалийн мэдүүлэгт нефтийн завсрын бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн гэж өөр өөрөөр тодорхойлж бүртгэсэн байна.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нефтийн завсрын болон нэмэлт бүтээгдэхүүн гэсэн нэр томъёо байхгүй тул аудитын сэдвийн нефтийн гэсэн нэрийг аудитын тайланд “газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүн” гэж бичив.

Аудитын тайланд дурдах газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний нэр томьёоны тайлбарыг оруулав. Үүнд:

1. **Алкилат** нь октан тоо өндөртэй бензиний найрлагад ордог үндсэн бүрдүүлэгчийн нэг юм.
2. **Нафта** нь газрын тос, хийн конденсатын шууд нэрлэгийн бензиний фракц (хөнгөн нэрдэс) буюу завсрын бүтээгдэхүүн. Дахин боловсруулж өндөр октантай бензин үйлдвэрлэнэ.
3. **Керосин** нь керосины фракц, техникийн керосин гэх мэт олон төрөлтэй байдаг. Иймд керосин гэж ерөнхий нэрээр нэрлэж болохгүй.
4. **Керосины фракц** нь бензиний фракцын дараа 150-315⁰С-д нэрж гаргадаг дунд зэргийн хөнгөн нэрдэс буюу завсрын бүтээгдэхүүн. Керосины фракцыг хүхрийн цэвэрлэгээнд оруулж, онгоцны болон дизелийн түлш үйлдвэрлэнэ.
5. **Техникийн керосин** нь газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний төрөлд орохгүй, эцсийн бүтээгдэхүүн юм. Техникийн керосины зориулалт нь өөр өөр байдаг. Тухайлбал: уусгагч байдлаар детал эд ангийг угаахад, түүхий эд байдлаар химийн үйлдвэрт этилен, пропилен, үнэрт нүүрсустөрөгч зэргийг гаргаж авахад, шил болон шаазан, эдлэлийг хийхэд түлш байдлаар тус тус хэрэглэдэг.
6. **Хүнд фракцийн дизелийн түлш** гэж газрын тосны нэрлэгийн хүнд фракцыг (Вакуум газойль) боловсруулан гаргаж авсан бүтээгдэхүүнийг хэлнэ. Судовое маловязкое топливо-гэсэн нэр томьёог усан замын хөлөг онгоцны зууралдлага багатай түлш гэж орчуулдаг.

БҮЛЭГ 1. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГЫН ЗОРИЛТ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ, ХУУЛИАР ТОГТООСОН ЭРХ ЗҮЙН АКТУУДЫГ БҮРЭН БОЛОВСРУУЛЖ БАТЛААГҮЙ, ЗАСГИЙН ГАЗАР, ЯАМ, АГЕНТЛАГ ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод тусгасан арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

1.1 Улсын Их Хурлаас газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар дараах бодлогын баримт бичгүүдийг баталсан байна. Үүнд:

- *Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 /2016 оны 19 дүгээр тогтоол/*
- *Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого /2018 оны 169 дүгээр тогтоол/*
- *Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр /2016 оны 45 дугаар тогтоол/*
- *Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого /2020 оны 52 дугаар тогтоол/*

1.2 Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны бодлогын 2.1.3-т “Аж үйлдвэрийн салбар”-ыг 2030 он хүртэл тогтвортой хөгжүүлэх зорилтыг “Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана” гэж тодорхойлж, дараах 3 үе шатаар хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- **I үе шат (2016-2020):** Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.
- **II үе шат (2021-2025):** Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 70 хувийг Евро 5 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
- **III үе шат (2026-2030):** Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр 100 хувь хангах, зэс хайлуулах, алт цэвэршүүлэх, улмаар газрын тос, байгалийн хий, занар, нүүрс боловсруулах, химийн бүтээгдэхүүн болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

1.3 Дээрх зорилтын нэгдүгээр үе шат буюу 2016-2020 онд аж үйлдвэрийн салбарт дэвшүүлсэн зорилтын хүрэх үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаагүйгээс үр дүн хангалтгүй, зорилт бүрэн хэрэгжээгүй байна.

1.4 Тухайлбал гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах зорилт хэрэгжээгүй 100 хувь импортоор орж ирсэн шатахуун хэрэглэсээр байна.

1.5 Мөн газрын тосны үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, үр дүн хангалтгүй байгаа нь тус үзэл баримтлалын 2.4-т заасан Тогтвортой хөгжлийн засаглалд “Төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулж, тогтвортой байдлыг хангах” чиглэлээр тусгасан зорилт, зарчмыг Засгийн газар түүний харьяа холбогдох байгууллагууд хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

1.6 Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогыг баталсан бөгөөд үүний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/168 дугаар тушаалаар баталжээ.

1.7 Тус бодлогын баримт бичигт газрын тосны салбарыг хөгжүүлэхэд баримтлах 6 чиглэл, хүрэх үр дүнг тодорхойлж, 32 зорилтыг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

1.8 Бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх үр дүнг үнэлэх хүрэх түвшний 11 шалгуур үзүүлэлтийг баталжээ.

1.9 “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг УУХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт үнэлгээг 86.0 хувь гэж үнэлсэн байна.

УУХҮЯ-ны төрөөс газрын тосны талаар баримтлах бодлогын хүрэх түвшинд хийсэн үнэлгээ

Хүснэгт-2

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт 2017 он	Хүрэх түвшин 2020 он	Хүрсэн түвшин 2020 он	Үнэлгээ /хувь/	Аудит
2	2.2.2. Газрын тос боловсруулах үйлдвэрийн байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх	2.1 Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл	сая.тонн	ТЭЗҮ боловсруулж байна.	Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсон байна.	ТЭЗҮ хийсэн,дэд бүтцийг ашиглалтад авсан, төсөл хэрэгжүүлэгч МГТБҮ болно.	80	80
		2.2 Нийлэг байгалийн хий болон бусад дайвар бүтээгдэхүүний үйлдвэрлэл	сая.м3	ТЭЗҮ боловсруулсан	Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр баригдсан байна.	ЗГ-н 2020 оны12 сарын 09-ний өдрийн хуралдаанаар санхүүжүүлэх барьж байгуулах гүйцэтгэчийг олон улсад сонгон шалгаруулах тэмдэглэл гаргуулсан.		
3	2.2.3. Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах	Газрын тосны бүтээгдэхүүний тоо хэмжээ	сая.тн	1.5	1.6	1.6	95.7	58.8
		Чанар, экологийн ангилал, к5	хувиар	7.7	50	11		

Эх сурвалж: УУХҮЯ-ны ХШҮДАГ-ын үнэлгээний тайлан

1.10 Үүнээс аудитын сэдэвт хамаарах 2.2.3-д заасан “Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог сайжруулах” зорилтыг 95.7 хувь биелсэн гэж үнэлснийг дахин хянахад дундаж үнэлгээ нь 58.8 хувийн хэрэгжилттэй зөрүүтэй үнэлсэн байна.

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Евро-5 стандартын шатахууныг импортолсон нийт шатахууны 50 хувьд хүргэх зорилт хэрэгжээгүй байна.

1.11 Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “хот суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн байна.

- 1.12 Үүний дагуу Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-ийг баталж, уг хөтөлбөрийн 2.2.3-т “автоматээр хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах” гэсэн зорилтыг тусгасан байна.
- 1.13 Дээрх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 4.3.2-т “Евро-5 стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны импорт, хэрэглээг дэмжих, стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг импортоор оруулах, хэрэглэхийг үе шаттайгаар хориглох, шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах” гэж заасан байна.
- 1.14 Мөн “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г салбар дундын уялдааг ханган боловсруулж, батлан хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад даалгасан байна.
- 1.15 Үүний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/107 тушаалаар Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.
- 1.16 Тус төлөвлөгөөнд үндэсний хөтөлбөрийн 4.3.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5 шалгуур үзүүлэлтийг баталсан байна.
- 1.17 Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-ийг баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг “Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо”-нд үүрэг болгосон байна.
- 1.18 Үүний дагуу Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо 2020 оны байдлаар Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 70 хувьтай үнэлсэн байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-4

Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хэрэгжилт хариуцах байгууллага
Стандартыг боловсруулж батлуулсан байна.	Евро-5 стандартын жишигт нийцсэн дизелийн түлш. Евро. Техникийн шаардлага. MNS 216:2017; Хөдөлгүүрийн түлш. Этилжүүлээгүй бензин. Техникийн шаардлага MNS 217:2017. гэсэн 2 стандарт батлуулсан байна.	УУХҮЯ
Евро-5 стандартын автобензин, дизелийн түлш хэрэглээнд нэвтэрсэн байна.	Евро-5 стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизель түлш 186,001.7 мянган тонн буюу нийт импортын 12.8 хувийг эзэлж байна.	УУХҮЯ
Евро стандартын шаардлага хангасан түлш, шатахуун импортолж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх итгэмжлэгдсэн лабораторийг бий болгосон байна.	АМГТГ-ын дэргэдэх Уул уурхай, газрын тосны төв лаборатори нь газрын тосны бүтээгдэхүүний сорилт, шинжилгээ гүйцэтгэх итгэмжлэл авсан ба лабораторийн техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал, шинжилгээний нарийвчлалыг нэмэгдүүлэх хүрээнд Улсын төсвийн 1.2 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Евро-5 стандартын үзүүлэлтүүдийг нарийн шинжлэн тогтооход шаардлагатай 7 нэр төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авч суурилуулан ажиллуулж эхэлжээ.	УУХҮЯ
Импорт, хэрэглээнд тавих чанарын хяналтын тогтолцоо сайжирсан байна.	НМХГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд 89 шатахуун хадгалах агуулах, шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил арилгуулахаар 33 албан шаардлага, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөөгүй 12 шатахуун түгээх станц /ШТС/-ын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох 12 акт үйлдэн хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 18.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллажээ.	УУХҮЯ, АМГТГ

Шатахуун станцуудад тавьж, буцаах суурилуулсан байна. түгээх шаардлага хийн систем	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, автомашин хийгээр цэнэглэх станц /АХЦС/-уудын газрын зөвшөөрөл, зориулалт, гэрээ, гэрчилгээ, байршил, барилга, байгууламж, техник, тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралт, ашиглалт, газрын тосны бүтээгдэхүүний чанар, хадгалалтын байдалд шалгалт хийсэн. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 2221 ШТС, 55 АХЦС-уудын шатахуун болон шингэрүүлсэн шатдаг хий хадгалах савнуудын бүртгэлийг шинэчлэн, улсын бүртгэлд хамрагдаагүй савны тоог гаргаж, МХЕГ, АМГТГ-т бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулжээ.	УУХҮЯ, АМГТГ
--	---	--------------

Эх сурвалж: Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2020 оны тайлангаас

1.19 Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 4.3.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж, зорилтот түвшинд хүргэх чиглэлээр хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх ажил хэрэгжээгүй байна.

1.20 Аудитаар үндэсний хөтөлбөрт заасан “Евро-5” стандартад нийцсэн шатахууны эзлэх хувь 2019 онд нийт шатахууны 50 хувьд, 2025 онд нийт шатахууны 80 хувьд хүргэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийв.

Дүрслэл-4



Эх үүсвэр: ГЕГ-аас

1.21 Дээрх шинжилгээнээс үзэхэд нийт импортлолсон шатахуунд Евро-5 стандартын шатахуун 2019-2021 онд дунджаар 9.3 хувь эзэлж байгаа нь үндэсний хөтөлбөрийн 50 хувьд хүрэх шалгуур үзүүлэлтийн биелэлт хангалтгүй байна.

1.22 Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-ын баримт бичиг батлагдаж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” урт хугацааны бодлогын баримт бичиг хүчингүй болсон байна.

1.23 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-ын баримт бичигт газрын тосны чиглэлээр дараах зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

- Зорилт 4.2. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилтын хүрээнд 4.2.16.-д “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна.” гэж заажээ.

- 1.24 Дээрх эдийн засгийн зорилтын хүрээнд газрын тосны салбарт чиглэсэн арга хэмжээний хүрэх үр дүн, “Төрөөс газрын тосны талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн хүрэх түвшнээс зөрүүтэй байна. Тухайлбал:

Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд тусгасан хүрэх түвшин

Хүснэгт-3

МУЗГ-ын 2018 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлого”-д тусгасан хүрэх түвшин	УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д тусгасан хүрэх үр дүн
Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2022 онд газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орсон байна.	тусгаагүй
Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 2027 онд Дотоодын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээний 50% (1.2 сая.тонн)-аас доошгүйг хангасан байна.	тусгаагүй
2022 онд Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр баригдсан байна.	тусгаагүй
2027 онд Нийлэг байгалийн хийгээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна.	тусгаагүй
Газрын тосны бүтээгдэхүүний тоо хэмжээг 2022 онд 1.9 хувь, 2027 онд 2.4 хувьд хүрсэн байна.	тусгаагүй
Чанар, экологийн ангилал, к5-ийг 2022 онд 50 хувь, 2027 онд 80 хувьд хүрсэн байна.	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь хэмжээг 2025 онд 70 хувь, 2030 онд 100 хувь, 2050 онд 100 хувьд хүрсэн байна.

Эх сурвалж: Аудитын судалгаа

- 1.25 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын баримт бичигтэй уялдуулж, салбарын богино, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг боловсруулан батлуулах шаардлагатай байна.

- 1.26 Хууль эрх зүйн зохицуулалтын хувьд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Онцгой албан татварын тухай хуулиудад газрын тосны бүтээгдэхүүний талаар өөр өөрөөр тодорхойлж тайлбарласан байгаагаас үзэхэд нэр томъёоны нэгдсэн ойлголт стандарт байхгүй байна. Үүнд:

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “газрын тосны бүтээгдэхүүн” гэж газрын тос болон химийн нэгдлүүдийг боловсруулах замаар гарган авсан бүх төрлийн шатахуун, тусгай шингэн, шатдаг хий, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг;
- Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн”, керосин. /Тайлбар: Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн гэдэгт хүнд фракцын дизелийн түлш, нафта, алкилатыг ойлгоно./ гэж тус тус тодорхойлсон байна.

- 1.27 Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд бүтээгдэхүүний үйлдвэрт тавигдах шаардлага, үйлдвэрлэх технологийн талаар нарийвчлан тусгаагүй байна.

Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнд хяналт тавих төрийн байгууллагуудын эрх зүйн орчин, зарим чиг үүрэг тодорхойгүй, ажлын уялдаа хангалтгүй байна.

- 1.28 Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2¹-т тусгасан газрын тосны бүтээгдэхүүний талаарх чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан байна.

¹ “газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, хөрөнгө оруулалтын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;”

“газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;”

- 1.29 Бүрэн эрхийн хүрээнд УУХҮЯ “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.10.13²-т заасныг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжүүдэд олгосон байна.
- 1.30 Аудитын хамрах хугацаанд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 23 аж ахуйн нэгж байснаас 16 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж, 2021 оны байдлаар 7 аж ахуйн нэгжийнх хүчинтэй байгаагийн 3 аж ахуйн нэгж нь үйлдвэрийн барилга, байгууламжтай эсэх нь тодорхойгүй байна. /Хавсралт 1, 2/
- 1.31 Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл олгохдоо бичиг баримтын хүрээнд олгосон нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавихад хүндрэл учруулж байгаа бөгөөд журамд нарийвчилсан зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.
- 1.32 Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3³-т заасан дүрэм, журам, нормыг батлахдаа үйлдвэрлэл эрхлэхтэй холбоотой зохицуулалтыг мөн нарийвчлан тусгаагүй байна.
- 1.33 “Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын хяналт шалгалт хийх тухай” УУХҮС-ын 2017 оны А/224 дүгээр тушаалын дагуу АМГТГ-ын даргын 2017 оны А/228 тушаалаар УУХҮЯ, АМГТГ, МХЕГ, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар зэрэг байгууллагуудаас ажлын хэсэг томилж, газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилт, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон бөөний, жижиглэнгийн худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн агуулахын бүтээгдэхүүнд чанарын хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтын үр дүнгээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.
- 1.34 **Ашигт малтмал газрын тосны газар нь** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаар мэдээллийн сан бүрдүүлэх, бодлого зохицуулалтад шаардлагатай нэмэлт судалгаа, мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх, олон улсын биржийн үнийг судлах, импортлогчийн нийлүүлэгчээс худалдан авах үнийг хянах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.
- 1.35 Тус газар нь газрын тосны бүтээгдэхүүний талаарх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ импортлогч аж ахуйн нэгжүүдээс импорт болон үлдэгдэл нөөцийн судалгааг авч мэдээ тайлан гаргаснаас бусад чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

“газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын асуудалтай холбогдсон дүрэм, журам, нормыг баталж, мөрдүүлэх;”


“газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөөцийн талаар санал боловсруулан Засгийн газраар шийдвэрлүүлж хэрэгжүүлэх;”

“газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмыг баталж мөрдүүлэх.”

² “газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх;”

³ “газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын асуудалтай холбогдсон дүрэм, журам, нормыг баталж, мөрдүүлэх;”

Төрийн байгууллагуудын газрын тосны бүтээгдэхүүний үйл явцад тавих хяналтыг дүрслэлээр харуулбал:



Дүрслэл-5. Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт хийх үе шат

- 1.36 **Гаалийн ерөнхий газар нь** Монгол Улсын хилээр бараа, бүтээгдэхүүнийг импортлоход хүлээн авах үеийн шинжилгээг Гаалийн төв лабораторид хийж, бараа бүтээгдэхүүний ангилал, нэр төрөл БТКУС-ийн кодыг тодорхойлж, гаалийн хяналт, шалгалт хийн гаалийн болон бусад албан татварыг ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.
- 1.37 Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт хийх лабораторийн шинжилгээг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2.-д *“импортлохсон бүтээгдэхүүн олон улсын стандартад нийцсэн эсэх талаар итгэмжлэгдсэн сорилтын лабораториор дүгнэлт гаргуулах,”*-аар заасан байна.
- 1.38 Гаалийн төв лабораторийг 1996 онд ГЕГ-ын даргын 348 дугаар тушаалаар анх байгуулжээ. 2007-2010 онд “Гаалийн салбар лаборатори” төслийн хүрээнд Замын-Үүд, Алтанбулаг, Дорнод, Чойр, Баян-Өлгий, Бичигтийн боомт дээр салбар лабораториудыг байгуулан, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна. /Хавсралт 3/
- 1.39 Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа газрын тосны завсрын болон нэмэлт бүтээгдэхүүнүүдийг гаалийн мэдүүлэгт олон янзын нэр, нэршлээр бүртгэж байна. Эдгээр завсрын болон нэмэлт бүтээгдэхүүнүүдийн тайлбарыг Хавсралт 4-д харуулав.
- 1.40 Манай улсад мөрдөж байгаа газрын тосны бүтээгдэхүүн, завсрын нэмэлт бүтээгдэхүүний зарим стандартууд нь үйлдвэрлэгч байгууллагын бүтээгдэхүүний чанарын гэрчилгээнд тусгасан олон улсын стандартаас зөрүүтэй байна. /Хавсралт 5/
- 1.41 Гаалийн бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар нь ГЕГ-ын даргын 2015 оны А/134 дүгээр тушаалаар баталсан *“Гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналт шалгалт хийх журам”*-д заасны дагуу газрын тосны завсрын болон нэмэлт бүтээгдэхүүн импортоор оруулж ирсэн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, борлуулалт, барааны үлдэгдэл, хадгалалтад гаалийн бүрдүүлэлтийн дараах хяналт хийгээгүй байна.
- 1.42 **Мэргэжлийн хяналтын байгууллага нь** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдалд хяналт хэрэгжүүлэхээр заасан байна.
- 1.43 Энэ хүрээнд үйлдвэр эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах, барилга байгууламжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагааны байдалд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч үйлдвэрт тавигдах шаардлага болон бүтээгдэхүүн үйлдвэрлэх арга, технологийг эрх бүхий байгууллагаас боловсруулж батлаагүйн улмаас бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр, түүний үйл ажиллагаанд бүрэн хяналт тавиагүй байна.

- Дээрх байгууллагуудын газрын тосны бүтээгдэхүүний талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгээс харахад Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 4, 9, 10, 11 дүгээр зүйлүүдэд газрын тосны бүтээгдэхүүний импорт, хадгалалт, тээвэрлэлттэй холбоотой заалтууд тодорхой туссан боловч газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, технологи, үйл ажиллагаа, байгууламжийн талаар тодорхой тусгаагүй нь хууль эрх зүйн зохицуулалт дутуу байгааг харуулж байна.
- Мөн газрын тосны бүтээгдэхүүний талаар төрөөс баримталж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий УУХҮЯ, АМГТГ, МХЕГ, ГЕГ зэрэг байгууллагууд ажлын уялдаа холбоог хангаж ажиллаагүй, газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнд тавих хяналт хангалтгүй байна.

БҮЛЭГ 2. ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНГҮЙ БАЙНА.

Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөлд үндэслэн аж ахуйн нэгжүүдэд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

2.1. Аудитын хамрах хугацаанд бүх төрлийн шатахууныг импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 104 аж ахуйн нэгж байгаагаас УУХҮС-ын 2018 оны А/08 дугаар тушаалаар баталсан Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журмын 4.1.9⁴-д заасан газрын тосны завсрын бүтээгдэхүүн импортлох тохиолдолд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагыг зөрчин нэр бүхий 13 аж ахуйн нэгж нийт 188.3 мянган тонн газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлгүйгээр импортоор оруулж ирсэн байна. Хавсралт 6-д харуулав.

2.2. Монгол Улсын хилээр 2017-2021 онуудад импортолсон газрын тосны завсрын бүтээгдэхүүнийг импортын хэмжээг төрлөөр нь дараах хүснэгтэд харуулав.

Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний импорт төрлөөр /тонн/

Хүснэгт-6

Нефтийн завсрын бүтээгдэхүүн	2017	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Алкилат зэрэг нефть, химийн бүтээгдэхүүн	9,024	9,156	4,050	-	-	22,229	3%
Керосин	49,738	109,325	52,445	45,115	44,613	301,236	37%
Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц	24,120	18,976	7,112	5,291	1,891	57,389	7%
Нефтийн нэрлэгийн хүнд фракц	24,814	96,794	87,915	151,827	80,595	441,944	54%
Нийт дүн	107,695	234,250	151,522	202,233	127,098	822,798	100%

/Эх үүсвэр: ГЕГ-аас/

Аудитын хамрах хугацаанд нийт 822.3 мянган тонн газрын тосны завсрын болон нэмэлт бүтээгдэхүүн импортолсноос үйлдвэртэй гэж мэдээлсэн аж ахуйн нэгж 256.2 мянган тонн буюу 31 хувь, үйлдвэртэй эсэх нь тодорхойгүй аж ахуйн нэгж 566.6 мянган тонн буюу 69 хувийг эзэлж байна.

⁴ “Завсрын бүтээгдэхүүн /БТКУС-ын 27.10.12 90, 27.10.19 90, 27.10.20 90 г.м/ импортлох тохиолдолд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл,”

Аж ахуйн нэгжийн импортын мэдээ

Дүрслэл-6



2.3. 2021 оны 08 дугаар сараас эхлэн Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6. “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосинд 1 тонн, 6 дугаар зүйлийн 6.1.10. 1 тонн тутамд 285.0 мянган төгрөгийн ОАТ ногдуулахаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

2.4. ОАТ ногдуулснаас хойших импортын мэдээнд дүн шинжилгээ хийхэд нийт импортын 96 хувийг нэг аж ахуйн нэгжийн импорт дангаараа эзэлж байна.

Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний 2021 оны импорт аж ахуйн нэгжээр

Хүснэгт-7

Аж ахуйн нэгжийн нэр	2021 оны импортын хэмжээ тонн	Нийт импортод эзлэх хувь
Лекс-Ойл ХХК	122298	96%
Петро хаан ХХК	757	1%
Петролеумпродакшн ХХК	1457	1%
Трансгейт Интернэшнл ХХК	2407	2%
Эрдмин ХХК	179	0%
Нийт импорт	127098	100%

Тус аж ахуйн нэгжийн импортын завсрын нэмэлт бүтээгдэхүүний мэдээ /тонноор/

Хүснэгт-8

Газрын тосны зарим бүтээгдэхүүн	2021 нийт импорт	2022 оны 1-р улирлын импорт	2022.03.31 агуулахын үлдэгдэл	Зарцуулсан /4=1+2-3/
0	1	2	3	4
Керосин	43,615	5,561	-	49,176
Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц , нафта	1,891	-	-	1,891
Нефтийн нэрлэгийн хүнд фракц	76,792	10,929	54,040	33,681
Дүн	122,298	16,490	54,040	84,748

Эх сурвалж: /Агуулахын үлдэгдлийг АМГТГ-н 2022 оны 3 сард хийсэн агуулахын үзлэгийн мэдээнээс/

2.5. Аудитын баг газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөлтэй 7 аж ахуйн нэгж байгууллагаас үйлдвэрлэл явуулж байгаа аж ахуйн нэгжийн Багахангай дүүрэг, Орхон аймаг, Дорноговь аймаг, Сонгинохорхан дүүрэг дэх үйлдвэрийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан болно. Хавсралт 1-д харуулав.


2.6. Бүх төрлийн шатахууны 2017-2021 оны импорт болон борлуулалтын хэмжээг харьцуулж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- 90-с доош октантай автобензиний борлуулалт нь импортоосоо 2017 онд 48%-иар, 2018 онд 19%, 2019 онд 5%, 2020 онд 66%, 2021 онд 8%-иар тус тус давсан үзүүлэлттэй байна.


Дүрслэл 7



- 90-с дээш октантай автобензиний хувьд 2017 онд борлуулалтын орлого импортоосоо 20%, 2018 онд 32%, 2019 онд 6%, 2020 онд 8%, 2021 онд 4% тус тус давсан үзүүлэлттэй байна.



- Дизель түлшний хувьд 2017-2019 онуудын хооронд харьцангуй тогтвортой байснаа 2020 онд борлуулалт нь импортоосоо 18%-аар, 2021 онд 11%-хувиар тус тус давсан байна.



Дээрх байдлаас дүгнэхэд импортын хэмжээнээс борлуулалтын хэмжээ үргэлж давсан үзүүлэлттэй байгаа нь газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг хольж зах зээлд нийлүүлсэн байх эрсдэл байна.

Монгол Улсын хилээр импортолсон газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг ОАТ-т бүрэн хамруулж, хуулийн дагуу татвар суутгаж төсөвт төвлөрүүлсэн байна.

2021 оны 8 дугаар сарын 01-ээс хойш импортолсон газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний онцгой албан татвар

Хүснэгт 9

Барааны нэр	Нэр	Тоо	Х/Нэгж	Онцгой	Аудитын ОАТ-ын дахин тооцоолол	Зөрүү
Керосин, техникийн	Эрдмин ХХК ГХО	102,400	KG	29,184,000	29,184,000	0
Керосин	Петро хаан ХХК	180,420	KG	51,419,700	51,419,700	0
Керосин	Лекс-Ойл ХХК	2,674,349	KG	762,189,465	762,189,465	0
Керосин, техникийн	Петро хаан ХХК	340,600	KG	97,071,000	97,071,000	0
Керосин	Лекс-Ойл ХХК	2,727,415	KG	777,313,275	777,313,275	0
Керосин	Лекс-Ойл ХХК	2,724,246	KG	776,410,110	776,410,110	0
Керосин	Лекс-Ойл ХХК	2,750,700	KG	783,949,500	783,949,500	0
Бензин шатахууны конденсат фракц, үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүн	Лекс-Ойл ХХК	465,248	KG	132,595,680	132,595,680	0
Керосин	Лекс-Ойл ХХК	2,685,404	KG	765,340,140	765,340,140	0
Бензин, Галоша	Монголиан транс ложистик ХХК	400	KG	114,000	114,000	0
Түлш, нефтийн нэрлэгийн хүнд фракц	Лекс-Ойл ХХК	1,046,200	KG	298,167,000	298,167,000	0
Дүн				4,473,753,870	4,473,753,870	0

Эх үүсвэр: ГЕГ-н тоон мэдээнээс тооцоолол хийв.

2.9 Онцгой албан татвар ногдуулж эхэлснээс хойших Монгол Улсын хилээр импортоор орж ирсэн газрын тосны нийт бүтээгдэхүүний мэдээнээс газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг шүүж, татварын дахин тооцоолол хийж үзэхэд 1 тонн тутмаас 285000 төгрөгөөр татвар тооцон авч, Монгол Улсын төсөвт 4.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлого, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт заасан *“Евро-5 стандартын шатахууны импорт хэрэглээг дэмжиж, импортолсон нийт шатахууны 50 хувьд хүргэх”* зорилт, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй байна.
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулж Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэх шаардлагатай байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-д газрын тосны бүтээгдэхүүн *үйлдвэрлэхтэй* холбоотой зохицуулалтыг тусгаагүй байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Онцгой албан татварын тухай хуулиудад газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний нэр томьёог өөр өөрөөр тодорхойлж, тайлбарласан нь нэр томьёоны нэгдсэн ойлголт, стандартыг бий болгох шаардлагатай байгааг харуулж байна.
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд заасан “импортолсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зориулалт, зарцуулалт”-д хяналт тавих чиг үүргээ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрууд нь хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн жагсаалтад газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг (нафта, алкилат, хөнгөн нэрлэгийн бусад бүтээгдэхүүн) үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн гэж нэг ангилалд оруулж бүртгэсэн нь олон улсын стандартад нийцээгүй байна.
- Гаалийн төв лаборатори нь импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хүлээн авах үеийн чанарын хяналтыг хэрэгжүүлэхдээ хүхрийн агууламжийг тодорхойлох химийн шинжилгээг бүрэн хийхгүй байна.
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төсөлд үндэслэн аж ахуйн нэгжүүдэд газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.
- 2017-2021 онуудад борлуулсан автобензин, дизель түлшний хэмжээ импортын хэмжээнээс их байгаа нь газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн бус аргаар бий болгож борлуулдаг байх эрсдэлтэй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Их хуралд толилуулах нь:

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд бүтээгдэхүүний үйлдвэрийн талаарх зохицуулалтыг тодорхой нарийвчлан тусгаж, холбогдох төрийн байгууллагуудын хяналт тавих чиг үүргийг тодорхой болгосон эрх зүйн орчин бий болгоход анхаарах;
- Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт заасан Евро-5 стандартын шатахууны хэрэглээг дэмжих зохистой бодлого гаргаж зорилт, арга хэмжээг бүрэн хангахад дэмжих;

Монгол Улсын Засгийн газарт:

- Төрөөс газрын тосны талаар баримтлах бодлогын баримт бичгийг “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авах;
- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болгох зорилгоор чанар стандарт, экологийн ангилалтай уялдуулж татварын бодлогоор дэмжих арга хэмжээ авах;
- Импортолсон завсрын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий /Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар/ төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангахуйц зохицуулалтыг бий болгож шийдвэрлэх;
- Байгаль экологи, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа стандартын шаардлагад нийцээгүй газрын тосны бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх эрсдэлээс хамгаалах талаар тодорхой арга хэмжээ авч шийдвэрлэх;

Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдад:

- Үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгосны дагуу аж ахуйн нэгжүүдийн импортолсон завсрын, нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зориулалт, зарцуулалтад бүрэн хяналт тавих;
- “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-даа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой тусгах;
- Монгол Улсад үйлдвэрлэсэн газрын тосны бүтээгдэхүүний чанар стандартын шаардлага хангасан эсэхэд хяналт хэрэгжүүлэх зохицуулалтыг "Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль"-д тусгуулах саналыг боловсруулж батлуулах;

Ашигт малтмал, газрын тосны газарт:

- Газрын тосны бүтээгдэхүүний стандартууд /газрын тосны нэр томъёоны стандарт, керосин, дизель түлшний г.м/-ыг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг стандартын асуудал хариуцсан байгууллагуудтай хамтран зохион байгуулан шинэчлэх;
- Газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхтэй холбоотой стандарт, дүрэм, журам, нормын төслийг боловсруулж, газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний мэдээллийн сан бүрдүүлэн, импортолсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зориулалт, зарцуулалтад хяналт тавих;

Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт:

- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах талаар Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд шаардлага хүргүүлж шийдвэрлүүлэх;
- Монгол Улсад үйлдвэрлэсэн газрын тосны бүтээгдэхүүнийг чанар стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын дагуу хяналт тавьж ажиллах;
- Гаальд үйлдвэрлэлийн зориулалтаар мэдүүлж импортолсон газрын тосны завсрын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, зориулалт, зарцуулалтад хяналт тавих;

Гаалийн ерөнхий газарт:

- Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүний стандартын нэр төрлийн дагуу Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн кодыг бүтээгдэхүүний төрөл тус бүрээр нь тогтоох;
- Төв лабораторийн шинжилгээгээр импортолж байгаа газрын тосны бүтээгдэхүүний химийн шинж чанар, хүхрийн агууламж зэрэг зайлшгүй шаардлагатай чанарын үзүүлэлтийг бүрэн тодорхойлдог болох;

ХАВСРАЛТУУД:

Хавсралт 1

2021 оны байдлаар газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчинтэй байгаа аж ахуйн нэгжийн жагсаалт

д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн хугацаа		Тунгалаг бүтээгдэхүүний гарц, Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Шийдвэр	Үйлдвэртэй эсэх
		Олгосон	Дуусах			
1	Петролиум продакшн ХХК	2012-05-07	2024-06-30	Хийн конденсатаас А-80 үйлдвэрлэж байна.	ЭБЭХ-ний сайдын 2012.5.07-ны өдрийн тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон. Аж ахуйн үйлдвэрийн сайдын 2015.05.08-ны өдрийн 94 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон, УУХҮС-ын 2021.06.30-ны өдрийн А/180 тоот тушаалаар сунгасан.	Лекс ойл ххк болон Петролиум продакшн ХХК нар 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн - Газрын тосны бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрийн менежментийн гэрээ"-г 2 жилийн хугацаатайгаар байгуулан ажиллаж байна.
		2015-05-06				
		2021-06-30				
2	Лекс-Ойл ХХК	2019-10-16	2022-10-17	Дахивар бүтээгдэхүүн боловсруулах	УУХҮС-ын 2019.10.16-ны өдрийн А/166 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	
3	Зүүнбаян нефть ХХК	2014-07-10	2023-02-11	Газрын тос боловсруулах	УУХҮС-ын 2014.07.10-ны өдрийн 176 дүгээр тушаалаар. УУХҮС-ын 2018.02.12-ны өдрийн А/25 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Байхгүй
		2017-07-09				
4	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК	2019-08-08	2027-08-07	Дахивар бүтээгдэхүүн боловсруулах	УУХҮС-ын 2019.08.08-ны өдрийн А/166 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Баригдаж байгаа
5	Трансгейт интернэйшнл ХХК	2017-09-19	2023-12-21	Хийн конденсат боловсруулах	УУХҮС-ын 2017.9.19-ний өдрийн А/205 дугаар тушаал, УУХҮС-ын 2020.12.22-ны өдрийн А-327 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Тийм
6	PM ойл ХХК	2020-07-01	2023-07-01	Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх	УУХҮС-ын 2020.07.01-ний өдрийн А/194 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Байхгүй
7	Хай Би Ойл ХК	2021-01-21	2024-01-20	Дахивар бүтээгдэхүүн боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх	УУХҮС-ын 2021.01.21-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Тийм

Хавсралт 2

Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нийт аж ахуйн нэгжийн жагсаалт

/2017-2021 он/

Д/Д	Аж ахуйн нэгж	Регистрийн дугаар	ТЗ олгосон хугацаа	ТЗ дуусах хугацаа	Тунгалаг бүтээгдэхүүний гарц, Үйлдвэрлэх бүтээгдэхүүн	Шийдвэр	Үйлдвэртэй эсэх
1	Петролиумпродакшн ХХК	2578638	07-05-12	30-06-24	Хийн конденсатаас А-80 үйлдвэрлэж байна.	ЭБЭХ-ний сайдын 2012.5.07-ны өдрийн тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон. Аж ахуйн үйлдвэрийн сайдын 2015.05.08-ны өдрийн 94 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон, УУХҮС-ын 2021.06.30-ны өдрийн А/180 тоот тушаалаар сунгасан.	Тийм
			06-05-15				
			30-06-21				
2	МАК Си Ти Эл ХХК	3376443	13-05-14	13-05-17	Нүүрс шингэрүүлэх	УУХҮС-ын 2014.05.13-ны өдрийн 99 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
3	Цэвэр түлш ХХК	5529255	26-06-14	25-06-17	Биодизель үйлдвэрлэх	УУХҮС-ын 2014.06.26-ны өдрийн 164 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
4	Зүүнбаян нефть ХХК	2794705	10-07-14	11-02-23	Газрын тос боловсруулах	УУХҮС-ын 2014.07.10-ны өдрийн 176 дүгээр тушаалаар. УУХҮС-ын 2018.02.12-ны өдрийн А/25 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
			09-07-17				
5	Хэт ХХК	2041707	16-07-14	16-07-17	84 хувь АНУ-ын Ventech-ийн тернологи	УУХҮС-ын 2014.7.16-ны өдрийн 178 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
6	Мегофатт ХХК	2078414	20-01-15	20-01-18	Газрын тос боловсруулах	УУХҮС-ын 2015.01.20-ны өдрийн 12 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
7	Хар мөрөн Импекс ХХК	5935318	24-12-15	24-12-18	Газрын тос боловсруулах	УУХҮС-ын 2015.12.24-ний өдрийн 246 дугаартушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
8	Соут ойл ХХК	-	01-07-15	-	-	Аж үйлдвэрийн сайдын 2015.07.01-ний өдрийн 109 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
9	Алтан оршихуй групп ХХК	5537266	04-07-15	-	-	Аж үйлдвэрийн сайдын 2015.07.04-ний өдрийн 114 тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
10	МАУКорпораци, Либерти Партнерс ХХК	-	-	-	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр	ТЭЗҮ боловсруулагдан, АҮЯ-наас үйлдвэр байгуулах зөвшөөрөл авсан.	Үгүй

Газрын тос, нефтийн завсрын нэмэлт бүтээгдэхүүний талаар төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан

11	Монголын алт МАК ХХК	2095025	-	-	-	ТЭЗҮ боловсруулсан, ЭБМЗ-өөр батлагдан УУЯ-наас үйлдвэр байгуулах зөвшөөрөл авсан.	Үгүй
12	Багануур Энержи ХХК	-	-	-	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр	ТЭЗҮ боловсруулсан, ЭБМЗ-өөр баталсан УУЯ-наас үйлдвэр байгуулах зөвшөөрөл авсан.	Үгүй
13	Цэцэнс майнинг энд энержи ХХК	5482046	-	-	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр	-	Үгүй
14	Багануур ХК	2008572	-	-	Нүүрс шингэрүүлэх үйлдвэр	-	Үгүй
15	Эл Эн Жи Монголиа ХХК	6155901	06-09-17	05-09-20	Газрын тос боловсруулах	УУХҮС-ын 2017.09.06-ны өдрийн А/197 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
16	НТФ ХХК	6083625	03-10-17	02-10-20	Газрын тос боловсруулах	УУХҮС-ын 2017.09.06 А/212 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
17	Ди Би Ойл ХХК	6222056	05-12-18	05-12-21	Дахивар бүтээгдэхүүн боловсруулах	УУХҮС-ын 2018.12.05-ны өдрийн А/254 тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
18	Мон пити ойл ХХК	4388054	20-12-18	20-12-21	Дахивар бүтээгдэхүүн боловсруулах	УУХҮС-ын 2018.12.20-ны өдрийн А/261 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Тийм
19	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ХХК	6177492	08-08-19	07-08-27	Дахивар бүтээгдэхүүн боловсруулах	УУХҮС-ын 2019.08.08-ны өдрийн А/166 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
20	Лекс-Ойл ХХК	5623979	16-10-19	17-10-22	Дахивар бүтээгдэхүүн боловсруулах	УУХҮС-ын 2019.10.16-ны өдрийн А/166 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
21	Трансгейт интернэйшнл ХХК	2710811	19-09-17	21-12-20	Хийн конденсат боловсруулах	УУХҮС-ын 2017.9.19-ний өдрийн А/205 дугаар тушаал, УУХҮС-ын 2020.12.22-ны өдрийн А-327 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Тийм
22	РМ ойл ХХК	6494366	01-07-20	01-07-23	Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх	УУХҮС-ын 2020.07.01-ний өдрийн А/194 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй
23	Хай Би Ойл ХК	2615134	21-01-21	20-01-24	Дахивар бүтээгдэхүүн боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх	УУХҮС-ын 2021.01.21-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар тусгай зөвшөөрөл олгосон.	Үгүй

Эх сурвалж: УУХҮЯ-ны мэдээ

Хавсралт 3

Итгэмжлэгдсэн лабораторийн жагсаалт /2022 он/

№	Дугаар	Лабораторийн нэр	Байгууллагын нэр	Хөтөлбөр	Олгосон огноо	Дуусах огноо	Хамрах хүрээ	Хөтөлбөр
1	TL 25	Уул уурхай, газрын тосны газрын лаборатори	Ашигт малтмал, газрын тосны газар	MNS ISO/IEC 17025:2018	28-01-21	05-09-24	Үйлчилгээний цар хүрээ: Олон нийтэд Тусгайлсан салбар: Газрын тос Сорилтын төрөл: Хими / Физик	Сорилтын лаборатори
2	TL 17	Гаалийн төв лаборатори Салбар лаборатори: 1. Орхон гаалийн газар 2. Оюутолгой гаалийн газар 3. Сайншанд гаалийн газар 4. Дорнод гаалийн газрын Баянхошуу боомт дахь гаалийн газар 5. Баян-Өлгий гаалийн газрын Цагааннуур боомт дахь гаалийн газар	Гаалийн ерөнхий газар	MNS ISO/IEC 17025:2018	30-06-21	29-06-25	Үйлчилгээний цар хүрээ: Олон нийтэд Тусгайлсан салбар: Хүнс, Эрдэс баялаг, Газрын тос, Зам барилга Сорилтын төрөл: Хими/Физик	Сорилтын лаборатори
3	TL17-01	Замын-Үүд боомт дахь Гаалийн газрын лаборатори	Гаалийн ерөнхий газар	MNS ISO/IEC 17025:2018	30-08-19	04-11-22	Үйлчилгээний цар хүрээ: Олон нийтэд Тусгайлсан салбар: Хүнс, Зам барилга, Газрын тос Сорилтын төрөл: Хими / Физик	Сорилтын лаборатори
4	CL 01	Оношлогоо хэмжил зүйн лаборатори	Иргэний нисэхийн ерөнхий газар	MNS ISO/IEC 17025:2018	15-02-00	30-04-23	Шалгалт тохируулгын төрөл: Цахилгаан, Механик, Эзэлхүүн Үйлчилгээний цар хүрээ: Олон нийтэд	Шалгалт тохируулгын лаборатори
5	CL 01, TL 21	Оношлогоо, хэмжил зүйн лаборатори	Иргэний нисэхийн ерөнхий газар	MNS ISO/IEC 17025:2018	07-12-19	07-12-23	Шалгалт тохируулгын төрөл: Масс, Эзэлхүүн, Цахилгаан Үйлчилгээний цар хүрээ: Дотоод үйл ажиллагаанд	Шалгалт тохируулгын лаборатори
6	TL11-03	Шатах, тослох материалын лаборатори	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	MNS ISO/IEC 17025:2018	22-06-21	01-08-24	Үйлчилгээний цар хүрээ: Дотоод үйл ажиллагаанд Тусгайлсан салбар: Газрын тос Сорилтын төрөл: Хими / Физик	Сорилтын лаборатори
7	TL 29	Газран тос, газрын тосны шинжилгээний лаборатори	"Амбер" ХХК	MNS ISO/IEC 17025:2018	30-12-19	16-10-23	Үйлчилгээний цар хүрээ: Олон нийтэд Тусгайлсан салбар: Эрдэс баялаг Сорилтын төрөл: Хими / Физик	Сорилтын лаборатори
8	CL 11	Оношлогоо, шалгалт тохируулгын лаборатори	НИК ХХК	MNS ISO/IEC 17025:2018	12-05-19	05-07-23	Шалгалт тохируулгын төрөл: Эзэлхүүн, Дарлат Үйлчилгээний цар хүрээ: Дотоод үйл ажиллагаанд	Шалгалт тохируулгын лаборатори

Эх сурвалж: Шинжээчийн тайлангаас, тайлбар: <https://www.mnas.gov.mn/accredited/>

Хавсралт 4

Монгол улсын хилээр импортолж байгаа газрын тосны завсрын болон нэмэлт бүтээгдэхүүний нэршил

№	Нэр төрөл	Нэр төрөл хамаарагдсан бүтээгдэхүүнүүд			Нэршлийн тайлбар, санал, зөвлөмж
		Монгол улсын гаалийн мэдүүлэг дээрх одоо байгаа нэршлүүд	ОХУ-д (ОХУ-ын газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээ дээрх нэр, ГОСТ, ТУ, СТО стандартаар)	Олон улсад (ОХУ-ын газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн чанарын гэрчилгээ дээрх нэр болон бусад улсын ISO стандартаар)	
1	Алкилат	Бэлдмэл, нэмэлт, Alkylate Изооктан, триметилпентан Триметилпентан Ханасан нүүрсустөрөгч, Alkylate Ханасан нүүрсустөрөгч, изооктан, Alkylate Ханасан, нүүрсустөрөгч, изооктан Ханасан, цагираг бус нүүрсустөрөгчийн хольц, Alkylate Ханасан, цагираг бус нүүрсустөрөгч, ALkylate Ханасан, цагираг бус нүүрсустөрөгч, Триметилпентан (изооктан) Цагираг бус нүүрсустөрөгч, ханасан, Alkylate Цагираг бус нүүрсустөрөгч, ханасан, Триметилпентан (изооктан)	Өндөр октантай бензиний бүрдүүлэгч Алкилат (Компоненты бензиновые высокооктановые. Алкилат) Алкилбензин	Alkylate (alkyl gasoline) Light alkylate naphtha - CAS 64741-66-8	Алкилат, өндөр октантай бензиний бүрдүүлэгч
2	Керосин	Керосин Керосин КТ-1 Керосин техникийн Техникийн керосин Уусгагч, керосин		Kerosene CAS No.: 8008-20-6	Керосин, Керосины нэрдэс (фракц)
			Технический керосин (Technical kerosene) Техникийн керосин	Industry standard specification for kerosene (ASTM D 3699-90 summary)	Техникийн керосин
			Керосин осветительный КО Гэрэлтүүлгийн керосин	kerosene lighting, Kerosene Lamps	Гэрэлтүүлгийн керосин
			Авиационный керосин		Нисэх онгоцны керосин
3	Хөнгөн фракц, нафта	Бензин шатахууны конденсат фракц, үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүн Бензин, пиролизын Бэлдмэл, нефтийн нэрлэгийн хөнгөн фракц	Бензин прямогонный	Naphtha (petroleum) CAS№ 64741-64-6	Шууд нэрлэгийн бензины фракц, Нафта
			Бензин газовый стабильный		Тогтворжуулсан хийн бензин

		Бэлдмэл, хийн конденсатын хөнгөн нэрлэг Бэлдмэл, хөнгөн фракцын нэрлэгийн Бэлдмэл, хөнгөн фракцын нэрлэгийн (дистиллят) Бэлдмэл, хөнгөн фракцын нэрлэгийн, нафта Бэлдмэл, хөнгөн фракцын нэрэгдэс Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц (нэрэгдэс) Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц, хийн конденсатын Нефтийн нэрлэгийн хөнгөн фракцын бүтээгдэхүүн Нефтийн хөнгөн фракцын нэрлэгийн бүтээгдэхүүн Нэрмэл, хийн конденсатын Ханасан цагираг бус нүүрсустөрөгчийн хольц Шууд нэрлэгийн бензин (нафта)	Легкий дистиллят газового конденсата		Хийн конденсатын хөнгөн нэрдэс
4	Хүнд фракцын дизелийн түлш	Каталитикт крекингийн хөнгөн газойль	Газойль легкий каталитического крекинга	Light gas oil - catalytic cracking	Катализаорт крекингийн хөнгөн газойль
		Нефтийн нэрлэгийн хүнд фракц	Вакуумный газойль	Vacuum gas oil	Вакуум газойль
		Нефтийн нэрлэгийн хүнд фракцын бүтээгдэхүүн	марка Б		Марк Б
		Нефтийн хүнд фракцын нэрлэгийн бүтээгдэхүүн	лөгий газойль	light gas oil	Хөнгөн газойль
		Түлш, нефтийн нэрлэгийн хүнд фракц	тяжёлый газойль	heavy gas oil	Хүнд газойль
		Түлш, нефтийн хүнд фракцын, үйлдвэрлэлийн зориулалттай	Топливо маловязкое судовое	Marine low-viscosity fuel	Далайн хөлөг онгоцны зууралдлага багатай түлш
		Түлш, бага зууралдлагатай	Судовое маловязкое топливо CMT (DMA) вид I	Marine low-viscosity fuel Type I	Далайн хөлөг онгоцны зууралдлага багатай түлш төрөл I
		Түлш, нефтийн нэрлэгийн			
		Түлш, нефтийн нэрлэгийн хүнд фракцийн			
		Түлш, нефтийн хүнд фракц			
		Түлш, нефтийн хүнд фракцын			
		Түлш, нефтийн хүнд фракцын нэрэгдэс			
		Түлш, үйлдвэрлэлийн зориулалттай	Топливо судовое маловязкое вид II	Marine low-viscosity fuel. Type II	Далайн хөлөг онгоцны зууралдлага багатай түлш төрөл II
		Түлш, хүнд фракцийн			
		Түлш, хүнд фракцын дизелийн түлш			
		Хөнгөн газойль			
		Хүнд фракцийн дизелийн түлш			

Эх сурвалж: Шинжээчийн тайлангаас

Хавсралт 5

Зарим стандартууд дээр хийсэн дүн шинжилгээ

№	Стандартын дугаар нэр	Зөрчил, алдаа	Үүсэх эрсдэл, үр дагавар	Бусад улс, оронд байгаа эсэх	тайлбар
1	MNS ISO 1998-2006 Газрын тосны аж үйлдвэр	Мэргэжлийн үг хэллэг буруу орчуулагдсан, тодорхойлолт буруу	Олон янзаар бичигдэх, буруу ойлголт өгөх, төөрөгдөл үүсэх, баримт бичгүүд буруу гарах	НЕФТЬ И НЕФТЕПРОДУКТЫ Маркировка, упаковка, транспортирование и хранение. ГОСТ 1510-202	Мэргэжлийн үг хэллэгээр засаж, сайжруулах, нийтээр дагаж мөрдөх
2	MNS 6855 : 2020 Керосин. Техникийн шаардлага Kerosene. Technical Requirements	Керосин гэсэн ерөнхий нэрээр стандарт баталсан	Төөрөгдөл үүсгэх, баримт бичгүүд буруу гарах	Техникийн керосин (СТО48671436-013-2016) http://www.toplivoprodazha.ru/dokumenty/gost/kerosin/ Керосин технический экспортный СТО 48671436-013-2016- экспортод зориулсан техникийн керосин Үйлдвэрлэл- техникийн зориулалтаар буюу ароматик нүүрсустөрөгчид, пропилен, этилен үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглахаас гадна уусгагч болгож ашигладаг	ОХУ-д техникийн керосин гэсэн стандарт байна.
3	MNS 6859:2020 Хүнд фракцын дизелийн түлш. Техникийн шаардлага Heavy fraction diesel fuel. Specifications	Стандартын нэр буруу орчуулагдсан	Төөрөгдөл үүсгэх, баримт бичгүүд буруу гарах	СТ РК 3338-2018 Вакуумный газойль Технические условия. Вакуумный газойль применяется в качестве сырья установок каталитического крекинга и гидрокрекинга, ГОСТ Р 52755-2007 Топливо жидкое комpositное. Технические условия Источник: https://znaytovar.ru/gost/2/GOST_R_527552007_Topливо_zhidk.html ТОПЛИВО МАЛОВЯЗКОЕ СУДОВОЕ ТУ 38.101567-2014 Применение в среднеоборотных и высокооборотных дизельных двигателях	Хүнд фракцын дизелийн түлш гэсэн нэртэй олон улсын болон ОХУ-ын стандарт байхгүй байна. Усан онгоцны зууралдлага багатай түлш гэсэн стандарт байна.

Эх сурвалж: Шинжээчийн тайлангаас

Хавсралт 6

Газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлгүй импортолсон аж ахуйн нэгжийн жагсаалт

д/д	Компанийн нэр	Газрын тосны завсрын бүтээгдэхүүн	2017	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
1	Ай Си Ай Си ХХК	Нийт	53,270.00	87,637.00	5,145.00	-	-	146,052.00	0.18
		Алкилат зэрэг нефть, химийн бүтээгдэхүүн	7,468.00	6,374.00	-	-	-	13,842.00	-
		Керосин	34,062.00	81,263.00	5,145.00	-	-	120,471.00	-
		Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц	11,740.00	-	-	-	-	11,740.00	-
2	Ви Эс ойл ХХК	Нийт	-	1,034.00	18,613.00	-	-	19,647.00	0.02
		Керосин	-	1,034.00	18,613.00	-	-	19,647.00	-
3	Интеррелианс ложистик ХХК	Нийт	-	90	-	-	-	90	-
		Керосин	-	90	-	-	-	90	-
4	Куал-Ойл ХХК	Нийт	59	-	-	-	-	59	-
		Керосин	59	-	-	-	-	59	-
5	М-ойл групп ХХК	Нийт	322	-	-	-	-	322	-
		Керосин	322	-	-	-	-	322	-
6	Монсульт ХХК	Нийт	814	2,155.00	-	-	-	2,969.00	-
		Керосин	814	2,155.00	-	-	-	2,969.00	-
7	НИК ХХК	Нийт	1,597.00	3,909.00	-	-	-	5,507.00	0.01
		Керосин	1,597.00	3,909.00	-	-	-	5,507.00	-
8	Петро хаан ХХК	Нийт	-	9,931.00	-	126	757	10,814.00	0.01
		Керосин	-	9,931.00	-	126	757	10,814.00	-
9	Петростар ХХК	Нийт	826	622	-	-	-	1,447.00	-
		Керосин	826	622	-	-	-	1,447.00	-
10	Шинэ хими ХХК	Нийт	268	115	-	-	-	384	-
		Нефтийн нэрлэгийн хөнгөн фракц	268	115	-	-	-	384	-
11	Шунхлай ХХК	Нийт	190	-	-	-	-	190	-
		Керосин	190	-	-	-	-	190	-
12	Эрдмин ХХК	Нийт	77	230	154	77	179	717	-
		Керосин	77	230	154	77	179	717	-
13	Эрдмин ХХК ГХО	Нийт	-	-	-	77	-	77	-
		Керосин	-	-	-	77	-	77	-
	Нийт дүн		57,423.00	105,723.00	23,912.00	280.00	936.00	188,275.00	100%

Эх сурвалж: АМГТГ